

ГХБХБГ-ЫН 06 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

2019.06.06.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Энэ 7 хоногт сумдын газрын даамлуудаас газрын төлбөрийн судалгаа болон газар эзэмшигч ААНБ-ын судалгаа авч, нэгтгэж ажилласан болно.</p> <p>ГЗБГЗЗГ-ын ОЗМТХ-тэй хамтарч байгууллагын бүх албан хаагч болон 13 газрын даамал нарт албаны имэйл хаяг нээж өгсөн.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. Тухайлбал:</p> <p>Алтанцөгц сум: Аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн Т.Баатарт 4 жилийн газрын төлбөрийн судалгаа болон газар эзэмшигч ААНБ-ын судалгаа нийт газар өмчлөгчийн татварын ногдололтыг гаргаж явуулав.</p> <p>06-р сарын 01-ээс 06-р сарын 04 хүртэл аудитын ерөнхий газраас шалгаж байгаатай холбогдуулан бүх материалаа шалгуулж холбогдох судалгааг гаргаж өгч ажиллав.</p> <p>Улаанхус сум: Зөвшөөрөлгүй газарт хашаа татаж зам хаасан 3 иргэнд газар дээр нь очиж сумын Засаг даргын мэдэгдэх хуудас өгч зохих хууль журмыг танилцуулав.</p> <p>Газар өмчлөлийн гэрчилгээ авахаар хандсан 4 иргэнд сумын Засаг даргын захирамж, хянан баталгаа, кадастрын зураг гэх зэрэг холбогдох бичиг баримтуудыг нь бүрдүүлж өгсөн.</p> <p>Эзэмшилд байгаа газраа өмчлөхөөр хүсэлт гаргасан 2 иргэнд сумын Засаг даргын захирамж гаргуулав.</p> <p>2015-2018 оны газар олголтыг аудитын ерөнхий газраас шалгаж байгаатай холбогдуулан холбогдох тайлан тооцоо болон материалыг хавсралтын хамт гаргаж шалгуулав.</p> <p>1 иргэнд газар эзэмшлийн гэрчилгээ бичиж шинээр гэрээ байгуулав.</p> <p>1, 2, 3, 5, 11 -р багуудын иргэдийн нийтийн хуралд оролцож холбогдох хууль тогтоомжуудыг сурталчлав.</p>		

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР